

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/153/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх
Сүхбаатар сум	Утас: 7036-3040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
2026 он	Ахлах аудитор: Ц.Отгонбаяр
	Утас: 7036-3036 Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn
	Ахлах аудитор: Б.Наранцэцэг
	Утас: 7036-2442 Цахим хаяг: Narantsetsegba@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
А.ШИНЭ-ОД ТАНАА

2026.02.25 № СНА-2026/153/НА-СТА-ТЧЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор ажилчдын цалингийн доод хэмжээг 6 хувиар нэмэгдүүлэн баталсны дагуу цалин, нэмэгдэл хөлс, урамшуулал болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал өмнөх оноос 292,145.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэг нь 2010 онд боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа нь гүйцэтгэлээр санхүүжиж байгаа эрүүл мэндийн байгууллагын онцлогт нийцэхгүй, тухайн цаг үеэс хойш нягтлан бодох бүртгэлтэй холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам зэрэг хууль эрх зүйн актуудад орсон өөрчлөлтүүд мөрдөгдөхгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,237,428,895.43	627,927,796.22
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4	14,771,206.49	45,836,892.38
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө		14,771,206.49	45,836,892.38
31210	Төгрөг		14,771,206.49	45,836,892.38
31211	Төрийн сангийн харилцах		14,771,206.49	45,836,892.38
33	АВЛАГА	5	704,554,341.00	36,854,144.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		4,004,000.00	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		660,886,197.00	-
33500	Бусад авлага		39,664,144.00	36,854,144.00
33510	Байгууллагаас авах авлага		3,310,000.00	500,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага		36,354,144.00	36,354,144.00
34	УРЬДЧИЛГАА		-	21,620,000.00
34600	Урьдчилж гарсан зардал		-	21,620,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6	518,103,347.94	523,616,759.84
35100	Түүхий эд материал		485,049,513.94	482,596,847.04
35110	Тусгай зориулалттай материал		47,634,400.00	47,634,400.00
35130	Эм боох материал		437,415,113.94	434,962,447.04
35400	Хангамжийн материал		33,053,834.00	41,019,912.80
35410	Бичиг хэргийн материал		8,528,530.00	6,512,770.00
35420	Аж ахуйн материал		6,503,450.00	4,716,970.00
35430	Сэлбэг хэрэгсэл		8,021,640.00	8,021,640.00
35440	Түлш, шатах тослох материал		2,532,769.00	4,433,688.80
35450	Барилгын засварын материал		1,111,100.00	9,890,500.00
35460	Хүнсний материал		6,356,345.00	7,444,344.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		17,232,555,842.94	14,703,520,407.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	17,232,555,842.94	14,703,520,407.24
39200	Биет хөрөнгө		16,794,853,505.44	14,265,988,019.74
39201	Барилга, байгууламж, орон сууц		10,452,054,669.00	10,452,054,669.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		-1,399,155,185.19	-2,260,126,981.71
39203	Авто-тээврийн хэрэгсэл		998,152,214.80	978,152,214.80
39204	Хуримтлагдсан элэгдэл		-179,561,772.66	-262,095,050.59
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)		11,075,008,289.85	11,355,889,540.60
39206	Хуримтлагдсан элэгдэл		-4,724,064,071.40	-6,386,422,858.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		1,068,362,513.09	1,083,392,643.09
39208	Хуримтлагдсан элэгдэл		-499,453,258.81	-697,908,424.21
39214	Бусад үндсэн хөрөнгө		4,578,400.00	4,578,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		-1,068,293.24	-1,526,133.20
39300	Биет бус хөрөнгө		437,702,337.50	437,532,387.50
39301	Программ хангамж		12,494,800.00	12,494,800.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		-11,942,462.50	-12,112,412.50
39303	Бусад биет бус хөрөнгө		437,150,000.00	437,150,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		18,469,984,738.37	15,331,448,203.46
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		2,698,356,262.86	2,376,131,697.06
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9	2,698,356,262.86	2,376,131,697.06
41300	Өглөг		2,698,356,262.86	2,376,131,697.06
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		1,393,867,670.85	1,154,822,166.90
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		1,237,868,573.01	1,005,131,871.87
41360	Бусад өглөг		66,620,019.00	216,177,658.29
41361	Байгууллагад төлөх өглөг		55,020,019.00	204,577,658.29

41362	Хувь хүмүүст төлөх өглөг		11,600,000.00	11,600,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		15,771,628,475.51	12,955,316,506.40
51	Засгийн газрын хувь оролцоо		15,771,628,475.51	12,955,316,506.40
51100	Засгийн газрын оруулсан капитал		3,303,619,352.00	3,303,619,352.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		3,303,619,352.00	3,303,619,352.00
51200	Хуримтлагдсан үр дүн		5,110,701,445.03	2,294,389,475.92
51210	Өмнөх үеийн үр дүн		7,595,806,524.83	5,110,701,445.03
51220	Тайлант үеийн үр дүн		-2,485,105,079.80	-2,816,311,969.11
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		7,357,307,678.48	7,357,307,678.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		18,469,984,738.37	15,331,448,203.46

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тодор-уулга	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		15,515,166,828.10	16,835,153,537.86
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		1,859,384,143.10	16,835,153,537.86
120	Нийтлэг татварын бус орлого		1,859,384,143.10	1,342,488,193.93
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		398,414,170.01	1,015,982,558.11
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		343,850,480.01	407,461,965.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		54,563,690.00	608,520,593.11
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		1,311,352,039.00	92,964,385.07
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		149,617,934.09	233,541,250.75
122	Тусламжийн орлого		1,068,619,000.00	15,492,665,343.93
1221	Хандив тусламж /дотоод/		1,068,619,000.00	15,492,665,343.93
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого		1,068,619,000.00	2,281,497,491.93
122111	Урсгал санхүүжилтийн орлого		1,068,619,000.00	2,281,497,491.93
12215	Төсөв хоорондын хандив, тусламж		-	13,211,167,852.00
122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого \ЭМДС-УТ\		-	13,211,167,852.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		12,587,163,685.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		12,587,163,685.00	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		12,587,163,685.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		17,237,716,702.71	19,590,857,063.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ		17,237,716,702.71	19,590,857,063.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		17,197,302,396.12	18,997,539,022.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		9,248,324,859.00	9,494,646,704.85
210101	Үндсэн цалин		5,448,963,475.46	5,660,424,491.29
210102	Нэмэгдэл		3,115,992,755.06	3,339,117,338.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт		236,677,804.32	208,764,398.44
210104	Урамшуулал		446,690,824.16	286,340,476.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,096,617,858.51	1,142,441,717.08
210201	Тэтгэврийн даатгалын зардал		750,093,365.34	774,409,718.69
210202	Тэтгэмжийн даатгалын зардал		92,782,907.86	96,736,624.16
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал		65,837,097.83	77,530,148.24
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал		37,388,442.49	38,704,439.15
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал		150,516,044.99	155,060,786.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		969,751,599.41	2,253,378,291.93
210301	Гэрэл, цахилгаан		166,504,676.40	223,192,085.93
210302	Түлш, халаалт		582,195,367.01	1,858,360,700.00
210303	Цэвэр, бохир ус		221,051,556.00	171,825,506.00
2104	Хангамж, бараа материалын зардал		267,731,157.16	223,043,343.54
210401	Бичиг хэрэг		22,661,360.00	16,966,070.00
210402	Тээвэр, шатахуун		97,127,802.00	96,996,311.54
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		23,572,332.16	27,060,062.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		10,928,895.00	4,824,900.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		113,440,768.00	77,196,000.00
2105	Нормативт зардал		2,830,077,345.46	2,643,645,955.13
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		2,513,367,340.46	2,371,150,971.13
210502	Хоол, хүнс		293,608,795.00	262,228,684.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		23,101,210.00	10,266,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		114,174,912.00	276,387,260.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		5,316,000.00	-
210604	Урсгал засвар		108,858,912.00	276,387,260.00
2107	Томилолт, зочны зардал		25,494,250.00	20,497,500.00
210702	Дотоод албан томилолт		25,494,250.00	20,497,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		108,207,537.58	115,627,333.29
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		67,310,039.00	69,811,022.00
210803	Даатгалын үйлчилгээ		10,390,885.00	2,741,130.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		446,250.00	296,955.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		21,583,593.58	34,006,666.29
210807	Газрын төлбөр		362,000.00	403,480.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		8,114,770.00	8,368,080.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		2,536,922,877.00	2,827,870,916.45
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		8,690,600.00	2,924,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		2,528,232,277.00	2,824,946,816.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		30,950,800.00	593,318,041.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		30,950,800.00	593,318,041.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		-	451,851,691.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		-	130,164,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		30,950,800.00	11,302,350.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		-1,722,549,874.61	-2,755,703,525.41
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		762,555,205.19	60,608,443.70
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз		662,230,369.44	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		100,324,835.75	60,608,443.70
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-762,555,205.19	-60,608,443.70
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		-2,485,105,079.80	-2,816,311,969.11

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	13,511,265,069.01	17,168,534,099.04
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	400,414,170.01	1,014,982,558.11
120	Нийтлэг татварын бус орлого	400,414,170.01	1,014,982,558.11
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	400,414,170.01	1,014,982,558.11
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	343,850,480.01	407,461,965.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	56,563,690.00	607,520,593.11
122	Тусламжийн орлого	-	16,153,551,540.93
1221	Хандив тусламж /дотоод/	-	16,153,551,540.93
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	2,281,497,491.93
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	2,281,497,491.93
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	-	13,872,054,049.00
122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого \ЭМДС-УТ\	-	13,872,054,049.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	13,110,850,899.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,110,850,899.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,639,253,521.05	17,099,073,283.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,639,253,521.05	17,099,073,283.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,616,821,214.46	16,509,381,742.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,239,464,223.83	9,489,989,398.20
210101	Үндсэн цалин	4,290,967,779.06	5,131,828,836.70
210102	Нэмэгдэл	3,293,435,243.74	3,763,722,406.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	218,319,261.36	303,571,833.84
210104	Урамшуулал	436,741,939.67	290,866,321.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	852,329,138.80	1,384,640,527.68
210201	Тэтгэврийн даатгалын зардал	557,572,096.84	949,837,723.67
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	76,964,293.34	112,849,686.87
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	45,224,322.00	83,419,799.14
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	36,814,704.10	47,524,805.95
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	135,753,722.52	191,008,512.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,138,776,225.81	2,253,378,291.93
210301	Гэрэл, цахилгаан	166,504,676.40	223,192,085.93
210302	Түлш, халаалт	698,599,261.01	1,858,360,700.00
210303	Цэвэр, бохир ус	273,672,288.40	171,825,506.00
2104	Хангамж, бараа материалын зардал	253,192,976.43	209,667,772.00
210401	Бичиг хэрэг	18,495,120.00	3,953,650.00
210402	Тээвэр, шатахуун	82,399,302.00	89,621,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	26,688,059.43	32,188,992.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	19,497,895.00	5,060,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	106,112,600.00	78,843,480.00
2105	Нормативт зардал	2,829,857,155.01	2,918,442,923.34
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,463,917,188.01	2,714,602,228.34
210502	Хоол, хүнс	343,008,857.00	193,823,395.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	22,931,110.00	10,017,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	154,000,462.00	154,224,070.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	36,924,500.00	35,312,860.00
210602	Тавилга	555,390.00	1,040,000.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,841,520.00	-
210604	Урсгал засвар	113,019,052.00	117,871,210.00
2107	Томилолт, зочны зардал	22,158,800.00	10,807,500.00
210702	Дотоод албан томилолт	22,158,800.00	10,807,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	105,012,382.58	82,544,144.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	53,420,839.00	58,256,414.00
210803	Даатгалын үйлчилгээ	9,411,700.00	3,132,015.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	436,250.00	507,935.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	22,661,593.58	7,803,000.00
210807	Газрын төлбөр	362,000.00	403,480.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	18,720,000.00	12,441,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,029,850.00	5,687,115.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,029,850.00	5,687,115.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,432,306.59	589,691,541.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,968,800.00	589,691,541.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	451,851,691.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	130,164,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,968,800.00	7,675,850.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,463,506.59	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,463,506.59	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-127,988,452.04	69,460,815.89
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	44,776,780.00	38,395,130.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	44,776,780.00	38,395,130.00
2200	Дотоод эх үүсвэрээр	44,776,780.00	38,395,130.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	44,776,780.00	38,395,130.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-44,776,780.00	-38,395,130.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-172,765,232.04	31,065,685.89
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	187,536,438.53	14,771,206.49
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,771,206.49	45,836,892.38

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Бусад цэвэр хөрөнгө/ өмч	Хуримтлагдсан үр дүн	Хяналтын бус хувь оролцоо	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,303,619,352.00	7,357,307,678.48	-	7,595,806,524.83	-	18,256,733,555.31
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-	-
ХО-ын өсөлт, бууралт	-	-	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	20,702,000.00	-	-	-2,485,105,079.80	-	-2,464,403,079.80
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,303,619,352.00	7,357,307,678.48	-	5,110,701,445.03	-	15,771,628,475.51
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-	-
ХО-ын өсөлт, бууралт	-	-	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-2,816,311,969.11	-	-2,816,311,969.11
2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,303,619,352.00	7,357,307,678.48	-	2,294,389,475.92	-	12,955,316,506.40

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	17,639,433,500.00	17,168,534,099.04	470,899,400.96	97.1
12	Татварын бус орлого	17,639,433,500.00	17,168,534,099.04	470,899,400.96	97.1
120	Нийтлэг татварын бус орлого	1,298,912,800.00	1,014,982,558.11	283,930,241.89	78.1
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	394,365,000.00	407,461,965.00	-13,096,965.00	103.3
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	904,547,800.00	607,520,593.11	297,027,206.89	67.2
122	Тусламжийн орлого	16,340,520,700.00	16,153,551,540.93	186,969,159.07	98.86
122001	Хандив тусламж /дотоод/	14,052,548,200.00	13,872,054,049.00	180,494,151.00	98.7
122005	Төсвөөс санхүүжих	2,287,972,500.00	2,281,497,491.93	6,475,008.07	99.7
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,654,704,800.00	17,137,468,413.15	517,236,386.85	97.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,654,704,800.00	17,137,468,413.15	517,236,386.85	97.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,752,962,000.00	16,547,776,872.15	205,185,127.85	98.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,500,955,700.00	9,489,989,398.20	10,966,301.80	99.9
210101	Үндсэн цалин	4,787,552,000.00	5,131,828,836.70	-344,276,836.70	107.2
210102	Нэмэгдэл	3,440,453,300.00	3,763,722,406.49	-323,269,106.49	109.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	385,440,000.00	303,571,833.84	81,868,166.16	78.8
210104	Урамшуулал	887,510,400.00	290,866,321.17	596,644,078.83	32.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,386,490,300.00	1,384,640,527.68	1,849,772.32	99.9
210201	Тэтгэврийн даатгал	998,792,800.00	949,837,723.67	48,955,076.33	95.1
210202	Тэтгэмжийн даатгал	96,924,400.00	112,849,686.87	-15,925,286.87	116.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	48,462,200.00	83,419,799.14	-34,957,599.14	172.1
210204	Ажилгүйдлийн даатгал	48,462,200.00	47,524,805.95	937,394.05	98.1
210205	Эрүүл мэндийн даатгал	193,848,700.00	191,008,512.05	2,840,187.95	98.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,259,853,300.00	2,253,378,291.93	6,475,008.07	99.7
210301	Гэрэл, цахилгаан	210,187,400.00	223,192,085.93	-13,004,685.93	106.2
210302	Түлш, халаалт	1,858,360,700.00	1,858,360,700.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	191,305,200.00	171,825,506.00	19,479,694.00	89.8
2104	Хангамж, бараа материалын зардал	195,261,400.00	209,667,772.00	-14,406,372.00	107.4
210401	Бичиг хэрэг	5,000,000.00	3,953,650.00	1,046,350.00	79.1
210402	Тээвэр, шатахуун	76,503,000.00	89,621,650.00	-13,118,650.00	117.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	32,789,900.00	32,188,992.00	600,908.00	98.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,000,000.00	5,060,000.00	3,940,000.00	56.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	71,968,500.00	78,843,480.00	-6,874,980.00	109.6
2105	Нормативт зардал	3,062,995,900.00	2,918,442,923.34	144,552,976.66	95.3
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,901,544,500.00	2,714,602,228.34	186,942,271.66	93.6
210502	Хоол, хүнс	149,451,400.00	193,823,395.00	-44,371,995.00	129.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,000,000.00	10,017,300.00	1,982,700.00	83.5

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	177,119,200.00	192,619,200.00	-15,500,000.00	108.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	70,000,000.00	72,750,990.00	-2,750,990.00	103.9
210602	Тавилга	-	1,997,000.00	-1,997,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,000,000.00	-	3,000,000.00	-
210604	Урсгал засвар	104,119,200.00	117,871,210.00	-13,752,010.00	86.2
2107	Томилолт, зочны зардал	15,000,000.00	10,807,500.00	4,192,500.00	72.1
210702	Дотоод албан томилолт	15,000,000.00	10,807,500.00	4,192,500.00	72.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	125,286,200.00	82,544,144.00	42,742,056.00	65.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	98,661,100.00	58,256,414.00	40,404,686.00	59.0
210803	Даатгалын үйлчилгээ	3,411,700.00	3,132,015.00	279,685.00	91.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	509,200.00	507,935.00	1,265.00	99.8
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	360,000.00	-	360,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,000,000.00	7,803,000.00	1,197,000.00	86.7
210807	Газрын төлбөр	462,000.00	403,480.00	58,520.00	87.3
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	170,000.00	-	170,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	12,712,200.00	12,441,300.00	270,900.00	97.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,000,000.00	5,687,115.00	24,312,885.00	19.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,000,000.00	-	20,000,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,000,000.00	5,687,115.00	4,312,885.00	56.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	901,742,800.00	589,691,541.00	312,051,259.00	65.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	901,742,800.00	589,691,541.00	312,051,259.00	65.4
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	760,078,800.00	451,851,691.00	308,227,109.00	59.4
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	130,164,000.00	130,164,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,500,000.00	7,675,850.00	3,824,150.00	66.7
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-15,271,300.00	31,065,685.89	-46,336,985.89	-203.4
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,271,300.00	-31,065,685.89	46,336,985.89	-203.4
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	15,271,300.00	-31,065,685.89	46,336,985.89	-203.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	14,771,206.49	-14,771,206.49	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	45,836,892.38	-45,836,892.38	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0

610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	277	273	4	98.6
620001	Удирдах ажилтан	1	1	-	-
620002	Гүйцэтгэх ажилтан	237	222	15	93.7
620003	Үйлчлэх ажилтан	39	50	-11	128.2
65	Орон тооны мэдээлэл	277	273	4	98.6
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	235	216	19	91.9
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	42	57	-15	135.7

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **407,107.7** мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын 92,964.4 мянган төгрөг, үндсэн хөрөнгийн 233,541.3 мянган төгрөгийн дансны ангиллыг буруу бүртгэсэн,
- Мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдан авсан 38,395.1 мянган төгрөгийн дансны ангиллыг буруу бүртгэсэн,
- Мөнгөн гүйлгээний тайланд эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах зардлаас худалдан авсан 13,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг багаж, техник хэрэгсэл худалдан авах зардалд буруу бүртгэсэн,
- Түрээсийн 1,500.0 мянган төгрөгийн авлагыг бүртгэл тайланд дутуу тусгасан,
- “Сэлэнгэ цэнгэг ус” ОНӨААТҮГ-д өгөх 18,016.9 мянган төгрөгийн өглөгийг хасах утгаар илэрхийлсэн,
- Албан томилолтын 9,690.0 мянган төгрөгийн өглөгийг албан хаагч тус бүрээр бус бөөн дүнгээр бүртгэсэн,

Эдгээр нь Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.3.4² дэх, УСНББОУС 1-"Санхүүгийн тайлангийн толилуулга" 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой..." гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт", "Ангилал" батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Аудитаар нийт **177,616.8** мянган төгрөгийн зөрчил³ илэрснээс 976.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 161,510.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 15,130.8 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Төсвийн захирагчийн тайланд дараах мөнгөн орлого, зарлагыг тохируулна: Тухайн жилийн батлагдсан урсгал зардлын төсвөөр санхүүжүүлсэн хөрөнгийн шинжтэй гүйлгээг тохируулах бөгөөд тухайн гүйлгээ гарсан урсгал зардлын ангиллаас биет ба биет бус хөрөнгө худалдан авсан хөрөнгийн зардалд;

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 162,486.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 9,891.2 мянган төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

5.1. Төлбөрийн акт

5.1.1. Хоолны хөнгөлөлтийг зөрүүтэй тооцож, 12 ажилтанд нийт **976.0** мянган төгрөгийг илүү олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дахь “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон хоолны хөнгөлөлтийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2. Албан шаардлага

5.2.1. Өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөр үүсгэлгүйгээр буюу программын лицензийн төлбөрт 2,400.0 мянган төгрөг, илүү цагийн нэмэгдэл хөлсөнд 48,254.3 мянган төгрөг зэрэг нийт **50,654.3** мянган төгрөгийг тайлант оны төсвөөс шилжүүлсэн байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгэр сарын 01-ний өдрөөс эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, 7.3 дахь “Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан хэрэгжилтийг зохион байгуулна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.3-д “бүх өр төлбөр”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлан мэдээллийг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв илэрхийлэх албан шаардлага хүргүүлэв.

5.2.2. Батлагдсан төсвийг зардлын бүлэг, эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй **22,411.7** мянган төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах зардлаас багаж, техник хэрэгслийн зардалд 13,000.0 мянган төгрөгийг,
- Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх зардлаас бичиг хэргийн зардалд 5,413.2 мянган төгрөгийг,

- Хоол хүнсний зардлаас нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд 2,286.5 мянган төгрөгийг,
- Бага үнэтэй, түргэн элэгдэх, эд зүйлс худалдан авах зардлаас багаж, техник хэрэгслийн зардалд 1,350.0 мянган төгрөгийг,
- Мэргэжлийн үйлчилгээний төлбөрөөс тээврийн хэрэгслийн оношилгоонд 242.0 мянган төгрөгийг,
- Албан томилолтын зардлаас сургалтын зардалд 120.0 мянган төгрөгийг зэрэг.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.3. Анхан шатны баримтын бүрдэл дутуугаар **33,598.8** мянган төгрөгийн дараах ажил, гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Үүнд:

- Хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, гэрээ дүгнэсэн акт зэрэг анхан шатны нотлох баримтгүйгээр зөвхөн нэхэмжлэх, гэрээг үндэслэн хуулийн зөвлөгөө өгөх, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий Р.Атарцэцэгт 4,898.8 мянган төгрөгийн, эмгэг судлалын лаборант Э.Баатарсүхэд 2,200.0 мянган төгрөгийн өглөг үүсгэн 4,798.8 мянган төгрөгийг шилжүүлж, нийт 7,098.8 мянган төгрөгийн зардал тайлагнасан,
- Мэдээгүйжүүлгийн их эмч Б.Цэрэнтогтоход албан томилолтын хуудасгүйгээр 500.0 мянган төгрөгийн албан томилолт олгосон,
- Эмийн төлбөрийн е-баримт, эмчийн бичсэн эмчилгээний хуудас зэрэг анхан шатны баримтын бүрдэл дутуугаар 5 иргэнд 1,000.0 мянган төгрөгийн эмийн буцаан олголт олгосон,
- Эмийн захиалгын хуудсыг холбогдох албан тушаалтнаар хянуулж, баталгаажуулалгүйгээр буюу хянагдаагүй эмийн захиалгын хуудсаар 25,000.0 мянган төгрөгийн эм олгож, гүйцэтгэлд хяналтыг хэрэгжүүлээгүй зэрэг.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5 дахь “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно ...”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг

хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4-т “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны хүчин төгөлдөр баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.4. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд зөрчлийг давтан гаргасан **35,278.3** мянган төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Шалгуур хангаагүй гэх үндэслэлээр ЭМДС-аас нэхэмжилсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилт нь эх олонлогийн, системийн, эмч, байцаагчийн гэсэн 4 төрлөөр хасагдсан,
- Байгууллагын тасгуудын өрөөний урсгал засварыг хийж гүйцэтгэсэн гэх үндэслэлээр нэмэгдэл хөлс тооцож олгох хуудасгүйгээр буюу илүү цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулалгүйгээр 24 ажилтанд нийт 35,278.3 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг тооцож, олгосон.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3.1-д “Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ” гэсэн заалт болон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Чанар, төлбөрийн хяналтын журам”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.2.5. Дэмжих үйлчилгээний албаны дарга Б.Эрдэнэчимэг, байгууллагын соёл үйлчилгээний албаны дарга Б.Отгонбат, сувилахуйн албаны дарга Б.Мөнхцацрал, О.Эрдэнэцэцэг, арга зүйч П.Отгонцэцэг нарт 103 түргэн тусламжийн тасагт ээлжийн сувилагчаар ажилласан илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгохдоо сувилагчийн цалингийн ТҮЭМ-3 шатлалын цалингаас бус эрхэлж буй албан тушаалын цалингаас тооцож, нийт **15,566.9** мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалт болон Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”, 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цалин илүү олгосон зөрчлийг таслан зогсоож, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

5.2.6. Аймгийн ЭМГ-ын газар дээрх хяналт, шалгалтаар ХАБЭА-н тухай хуулийг сахин, хангуулах үүргээ биелүүлээгүй, эмийн сангийн эм тариаг хадгалах, түгээх нөөцийн өрөө хангалтгүй, өрөөний чийг хэмийг тогтмол баримтжуулаагүй зэрэг зөрчлүүд илэрч **4,000.0** мянган төгрөгийн торгууль ногдуулсан байна. Зөрчил гаргасан албан хаагчдад хариуцлага тооцолгүй торгуулийг мэргэжлийн үйлчилгээний төлбөрөөс төлж, батлагдсан төсвийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил гаргасан албан хаагчдад хариуцлага тооцох, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.7. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй буюу батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл дутуугаар ажил, гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан зэрэг зөрчлүүдийг давтан гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргасан нягтлан бодогч А.Шинэзаяад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Цалин хөлстэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Тайлант онд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Шинэ-Од, дэмжих үйлчилгээний албаны дарга Б.Эрдэнэчимэг, параклиникийн ажилтан Л.Бат-Эрдэнэ нарт зайлшгүй шаардлагаар ажилласан гэх үндэслэлээр ээлжийн амралтыг биеэр эдлүүлэлгүйгээр нийт **15,130.8** мянган төгрөгийн цалинг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх “Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ ...” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид ээлжийн амралтыг биеэр эдлүүлэн, батлагдсан төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулж байх.

Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 221 нэр төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох болон актлах саналыг холбогдох газарт хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэн заалттай нийцэхгүй, УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 13 (б)-д “... байгууллага нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнээр дахин үнэлэх хэрэгтэй...” гэсэн заалтууд болон болон “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж байгаа хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох болон актлах эсэх саналыг бэлтгэн, холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5⁴ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

⁴ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материалын дансны ангиллыг буруу бүртгэсэн	1	326,505.7			1	326,505.7	1	326,505.7				
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлын дансны ангиллыг буруу бүртгэсэн	1	38,395.1			1	38,395.1	1	38,395.1				
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан зардлын дансны ангилал буруу бүртгэсэн	1	13,000.0			1	13,000.0	1	13,000.0				
Түрээсийн авлагыг бүртгэл тайланд тусгаагүй	1	1,500.0	1	1,500.0			1	1,500.0				
Өглөгийн дансыг хасах утгаар илэрхийлсэн	1	18,016.9			1	18,016.9	1	18,016.9				
Албан томилолтын өглөгийг бөөн дүнгээр бүртгэсэн	1	9,690.0			1	9,690.0	1	9,690.0				
Дүн	6	407,107.7	1	1,500.0	5	405,607.7	6	407,107.7				

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Тоо	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин, хоолны хөнгөлөлтийг илүү тооцож, олгосон	1	976.0	1	976.0						
Өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөр үүсгэлгүйгээр цалин, төлбөрийг тайлант оны төсвөөс шилжүүлсэн	1	50,654.3			1	50,654.3				
Батлагдсан төсвийг зардлын бүлэг, эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй	1	22,411.7			1	22,411.7				
Анхан шатны баримтын бүрдэл дутуугаар ажил, гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан	1	33,598.8			1	33,598.8				
Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг тайлант онд давтан гаргасан	1	35,278.3			1	35,278.3				
Илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгохдоо албан тушаалын шатлалыг буруу тооцож, цалин илүү олгосон	1	15,566.9			1	15,566.9				
Ажлаа хангалтгүй биелүүлсэн албан хаагчдад хариуцлага тооцоогүй.	1	4,000.0			1	4,000.0				
Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг тайлант онд давтан гаргасан	1								1	
3 ажилтны ээлжийн амралтыг биеэр эдлүүлэлгүйгээр цалин давхардуулан олгосон	1	15,130.8					1	15,130.8		
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг шийдвэрлээгүй	1						1			
Дүн	10	177,616.8	1	976.0	6	161,510.0	2	15,130.8	1	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Телберийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаа хоцроосон, бүрэн мэдээлээгүй	1			1		
Дүн	1			1		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Дүн						
Нийт дүн						